



**ГОВЬСУМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, З дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2020.08.10 № 216

танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох “Сүмбэр сумын Монгол ардын нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

“Сүмбэр сумын Монгол ардын нам”-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцоо ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сүмбэр сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр /б...хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

СҮМБЭР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ СҮМБЭР
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМД

Б.САРАНТУЯА

D:\2020\Alban toot.doc

0080200366

Сумын МАНЫН ХОРООНЫ БҮХ ГИШҮҮДИЙН
2020 ОНЫ 06 САРЫН 18 НУУЦАА ДУГААР
ХУРЛЫН 03 ДУГААР ТӨГТӨОЛЫН ХАВСРАЛТ

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Монгол Ардын Намын хороо нь Монгол улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуулиудын хүрээнд 2020 оны орон нутгийн эзлжит сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрөө боловсруулан сонгогч түмэндээ толилуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын болон Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлж, сумын нийгэм здийн засгийн хөгжлийг тогтвортжуулан, ард иргэдийнхээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, орон нутагтаа үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх замаар өрхийн амьжиргааг дээшлүүлэн, тэдний хөгжих, эрүүл, аюулгүй орчинд амьдарч, сурч боловсрох таатай нөхцлийг бүрдүүлэн, төрийн үйлчилгээг чанартай, хөнгөн шуурхай, ил тод хүргэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Нэг. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Төрийн хууль дээдэлсэн шударга, цэгцтэй засаглалын бодлого баримтлана.

1.1 Төрийн албыг мэргэшсэн, чадварлаг, шударга, хариуцлагатай, улс төр, авлигаас ангид албан хаагчдаар бүрдүүлж, тогтвортсуурьшилтай ажиллуулна.

1.2 Төрийн албаны алдаа дутагдал гаргахгүй байж, төр иргэний итгэлцлийг бэхжүүлнэ.

1.3 Иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг шинэ шатанд гаргана.

1.4 Сумын төвийн багуудыг байртай болгож, хөдөөгийн багуудын төвийг үргэлжлүүлэн тохижуулж, иргэдэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй шуурхай хүргэнэ.

1.5 Суманд төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулна.

1.6 Хөдөөгийн багийн Засаг дарга нарыг унаажуулна.

1.6 Суманд цагдаагийн хэсэг шинээр байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн хэв журмыг сахиулах ажлыг чанаржуулан, иргэдийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

1.7 Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг чадварыг нэмэгдүүлж, болзошгүй гамшиг осол, эрсдлийн үед ажиллах дадлага олгоно.

0000000001

Андрей

Жаныбек

Мурзак

1.7 Иргэний бүртгэл мэдээллийг боловсронгуй болгож, үйлчилгээг чирэгдэлгүй хүргэнэ.

1.9 Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаад дотоодын төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

1.10 БНХАУ-ын ӨМӨЗО-ны аймаг, муж хотуудтай найрамдалт харилцаа тогтоож, харилцан үр ашигтай хамтран ажиллана.

Хоёр. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, хэмнэлтийг эрхэмлэн, сумын эдийн засгийн чадавхыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ.

2.1. Төсвийн хариуцлагыг сайжруулж, үр ашиггүй зардлыг багасган, төсвийг хэмнэх бодлого баримтлаж, хяналтыг чангатгана.

2.2. Орон нутгийн орлогыг оновчтой төлөвлөж, гүйцэтгэлийг хангаж ажиллана.

2.3 Сумын татварын бааз суурийг нэмэгдүүлж, орон тооны ажилтантай болно.

2.4. Сум хөгжүүлэх сангийн зээлийг хөгжлийн бодлоготой уялдуулан, иргэдийн оролцоо, хяналттайгаар олгож, үр ашгийг нь нэмэгдүүлнэ. Урьд жилүүдийн зээлийн эргэн төлөлтийг бүрэн төвлөрүүлнэ.

2.5. Иргэдийн бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөнгөн болон хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр, цех байгуулах иргэдийн үүсгэл санаачлагыг бодлогоор дэмжиж ажиллана.

2.6. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн хоршооны үйл ажиллагааг дэмжинэ. Суманд дундын хоршоо байгуулна.

Гурав. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Хүний хөгжлийг бүх талаар дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэн, иргэдийн амьжиргааг тогтвортой дээшлүүлж, иргэдийн боловсрол, соёл, эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

3.1. Нийгмийн халамжийн бодлогын хүрээнд

3.1.1 Зорилтот бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн жилд 50-иас доошгүй өрхийг хөгжүүлнэ.

0000000002



3.1.2 Залуучуудыг ажлын байртай болоход нь чиглэсэн мэргэжлийн сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг нь бодлогоор дэмжинэ.

3.1.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, залуучууд, хүүхэд гэр бүлийн нийгмийн хамгааллын асуудлаар хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

3.1.4. Аймгийн хэмжээнд батлагдсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.1.5. Залуучууд, залуу гэр бүлийг байр орон сууцтай болоход бүх талын дэмжлэг үзүүлнэ.

3.2. Боловсролын салбарын бодлогын хүрээнд

3.2.1. Сургуулиудын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, сургалтын тоног төхөөрөмжээр үе шаттай хангана.

3.2.2. 2 дугаар сургуулийн хичээлийн шинэ байрыг барьж ашиглалтанд оруулна.

3.2.3. 5 дугаар цэцэрлэгт өргөтгөл хийж, шинээр 150 хүүхдийн цэцэрлэг барина.

3.2.4. Цэцэрлэгүүдийн тоног, төхөөрөмж, техник хэрэгсэл, тоглоом, зөвлөн здлэлийн ашиглалтын хугацааг харгалzan ээлж дараатай шинэчлэнэ.

3.2.5 .Хувийн хэвшлийн сургууль ,цэцэрлэг байгуулахыг газрын бодлогоор дэмжинэ.

3.2.6 Хүүхэд харах үйлчилгээг орон нутагтаа хэрэгжүүлнэ.

3.3. Эрүүл мэндийн салбарын бодлогын хүрээнд

3.3.1.Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлж, тогтвортой суурьшилтай ажиллуулна.

3.3.2.Иргэдэд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй хүргэх бодлого баримтлана.

3.3.3.Хөдөөгийн багуудыг эмчтэй болгож, тогтвортой суурьшилтай ажиллуулах, нарийн мэргэжлийн үзлэг, оношлогооны чиглэлээр хөдөлгөөнт үйлчилгээ үзүүлнэ.

3.3.4. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тусlamж үйлчилгээг цаг хугацаанд нь чанартай хүргэнэ.

3.3.5. Хувийн эмнэлэг, сувилал байгуулахыг дэмжинэ.

3.4. Соёл урлаг, биентамир, спортын салбарын бодлогын хүрээнд

3.4.1.Боржигон түүх соёлын өвийг судлан сурталчлах, сэргээх арга хэмжээ авна.

3.4.2 Боржигин түүх соел, дурсгалт зүйлсийн тооллого явуулж бүртгэлжүүлнэ.

3.4.3.Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох , эрүүл аж төрөх ёс, зан үйлийг хэвшүүлж, биеийн тамир, спортын үйл ажиллагаанд иргэдийг тэгш оролцуулах боломжийг бүрдүүлнэ.

0000000003

Охир

Ж.М.С.
Н.Джамбулатов

3.4.4. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа урлагийн болон, биентамир спортын холбоодтой хамтран ажиллана.

Дөрөв. ХАА-Н САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Бүс нутгийн онцлогт тохирсон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн, үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.

4.1."Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого", "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана.

4.2. Эрчимжсэн мал аж ахуйг уламжлалт бэлчээрийн мал аж ахуйтай хослуулан хөгжүүлэхийг тэргүүлэх чиглэлээ болгоно.

4.3. Малын үүлдэр, угсааг сайжруулж, ашиг шимиийг дээшлүүлэх бодлого баримтлана.

4.4. Малын эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон төрийн бодлогын хэрэгжилтийг орон нутагтаа оновчтой зохион байгуулах, гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, эрүүлжүүлэх ажлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлнэ.

4.5. Хүнсний үйлдвэр, мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдэд эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал нэвтрүүлж, хүн амаа аюулгүй эрүүл хүнсээр хангах бодлого баримтлана.

4.6. Мал нядалгааны газар байгуулна.

4.7. Бэлчээр хамгаалах малчдын бүлэг байгуулан бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх арга хэмжээ авна.

4.8. Хөдөөгийн усан хангамж, хүрэлцээг нэмэгдүүлэх малчдын санаачлагыг дэмжинэ. Инженерийн хийцтэй 8, гар худаг 10-ыг байгуулна.

4.9. Өрх, иргэдийг төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж өөрсдийн хэрэгцээг хангах санаачлагыг дэмжинэ.

4.10 Сумын хэмжээнд "Мал хамгаалах хөтөлбөр", "Малжуулах хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.11 Сүмбэр үүлдрийн Каракуль хонины тоо толгойг өсгөх, чангартыг нь сайжруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, сумын бренд бүтээгдэхүүнийг бий болгоно.

1.12 Малын даатгалын тогтолцоог сайжруулж, сумын нийт малчин, мал бүхий өрхийн 40 хүртэл хувийг даатгалд хамруулна.

000000004

Тав. ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд ая тухтай амьдрах нөхцлийг чанаржуулж, хот тохижилтийг нэмэгдүүлнэ.


- 5.1 Сумын төвд Дулааны станц, цэвэрлэх байгууламж шинээр барина.
- 5.2. 1,2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны төвлөрсөн системд холбоно.
- 5.3. Нийтийн эзэмшлийн талбайд автозам, явган зам барих, зогсоол, гэрэлтүүлэг тавих, тохижуулах ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
- 5.4.Сумын төвийн хатуу хучилттай автозамыг нэмэгдүүлнэ.
- 5.5.1-р багийн орон сууцнуудыг бохир, цэвэр усны сүлжээнд холбох, хэсэгчилсэн халаалтад холбох ажлыг бодлогоор дэмжинэ.
- 5.6.Соёл, спорт, амралтын хүрээлэнгийн тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлнэ.
- 5.7.Орон сууцнуудын барилгын техникийн давхрыг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар засварлаж ашиглана.
- 5.8.Иргэдийн өмчлөлд олгосон газруудад цахилгаан татах ажлыг үргэлжлүүлнэ.
- 5.9 Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
- 5.10. Гэр хорооллын өнгө үзэмжийг сайжруулж, гудамж эгнээг жигдруүлэх, "Жишиг" гудамж эгнээ байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 5.11."Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг дэмжин техник тоног төхөөрөмж, ажиллах хүчээр бүрэн хангах бодлого барина.
- 5.12 Сумын төвд Гэрэлт гудамж байгуулна.
- 5.1.13 "Гомбосүрэн" ноёны талбайг цэцэрлэгт хүрээлэн болгон тохижуулна.

Зургаа. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчинд нөлөөлөгч хүчин зүйлүүдийн сөрөг нөлөөллийг бууруулж, байгаль орчны доройтлыг сааруулан, экологийн тэнцвэрт байдлыг хадгална.

- 6.1.Газрын харилцааны бодлогын хүрээнд**
 - 6.1.1 Сумын газар зохион байгуулалтын менежментийг сайжруулж, өмчлөлийн газрын хэмжээг нэмэгдүүлнэ.
 - 6.1.2.Ашигт малтмалын нөөцийн талаар судлан, мэдээлэлийн сан бүрдүүлж, хамгаалах, ашиглах, олборлолт явуулж буй газарт нөхөн сэргээлтийг тогтмол хийлгэнэ.

0000000005



6.1.3. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийг татан оролцуулж, бүсийн орчны бүлэг байгуулан ажиллана.

6.2. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын хүрээнд

6.1.1 Суманд хог ангилах, дахин боловсруулах үйлдвэр байгуулна.

6.2.2. Бүх нийтийн байгаль орчны боловсролыг дээшлүүлж, байгаль хамгаалахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.

6.2.3 Байгаль орчны талаар баримтлах бодлого, шийдвэрийг олон нийтэд хүргэх, шинэ мэдээ, мэдээллээр хангахад бүх төрлийн мэдээллийн хэрэгсэлийг өргөнөөр ашиглана.

6.2.4. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойн зурvas байгуулах иргэдийн санал, санаачлагыг дэмжиж, мод үржүүлгийн газар байгуулна.

6.2.5. Доройтох талхлагдсан бэлчээрийг хашиж хамгаалах, таримал бэлчээр бий болгох, бороо цасны ус хуримтлуулж цөөрөм, хөв байгуулах хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын санаачлагыг дэмжинэ.

6.2.6. Булаг шанд, рашаан усны эхийг хамгаалах арга хэмжээ авна.

6.2.7. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготно, хөнөөлт шавьжийн тоо толгой, тархалт, байршлийг тогтоон, устгал хийж, бэлчээр хамгаалах арга хэмжээ авна.

6.2.8. Устаж үгүй болох аюул нүүрлээд байгаа амьтны тоо толгойг нэмэгдүүлж, хамгаалалтыг сайжруулна.

6.2.9. Хуримтлагдсан хур хог хаягдал, туурь балгасыг цэвэрлэж нөхөн сэргээх ажлыг үе шаттайгаар хийнэ.

6.3. Аялал жуулчлалын бодлогын хүрээнд

6.3.1. Аялал жуучлалын цогцолбор, жуулчны бааз байгуулах иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.

6.3.2. Орон нутгийн аялал жуулчлалын маршрут гарган, аялалын хөтөлбөртэй болж, амралт зугаалгын зөвшөөрөгдөх бүс, отоглох, хоноглох бүс хил хязгаарыг тогтоон тэмдэгжүүлнэ.

6.3.3. Аяллын тогтсон маршрутын дагуу түүх, соёлын өвийг сэргээж, хамгаална.

ГОВЬСУМБЭР АЙМГИЙН МАНЫН ХОРОО

000000006

